



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 3.3 сая төгрөгийн зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаал, 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-г тус тус зөрчин 275.9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулж явуулсан зэрэг нийт 279.15 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Баясгаланд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэх асуудлыг таслан зогсоох;

2.3. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний өртгийн тооцоололт, зардлын хуваарилалтад анхаарч ажиллах;

2.4. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.5. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1 жил ба түүнээс дээш хугацаатай авлагыг барагдуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу найдваргүй авлагын нөөц байгуулах, энэ талаар холбогдох баримт бичигт тусгах, цаашид найдваргүй авлага үүсгэхгүй ажиллах;

0000712



2.6. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам боловсруулж, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.7. Мөнгөн кассын ажиллагааны журмыг боловсруулан мөрдөж ажиллах.

3. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХӨЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 2 дүгээр сарын 22-ны өдрийн  
22 дугаар тогтоолын хавсралт

“Дархан АЗЗА” ТӨХК-д хийсэн  
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын  
арилгах арга хэмжээний жагсаалт

| Д/д       | Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга                                                                       | Хамрах хугацаа | Үнийн дүн /сая төгрөг/ | Зөрчигдсөн эрхзүйн акт                                                                                                                                                                         | Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал                                                                                                                                          |
|-----------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1         | Тайлант онуудад баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан                    | 2017-2018 он   | 3.3                    | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг                                                                                                                  | Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, компанийн санхүүгийн эх үүсвэр, бодит хэрэгцээг тооцож баталгаажуулсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, батлуулах.      |
| 2         | 2017, 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй шууд худалдан авалт хийсэн                   | 2017-2018 он   | 199.2                  | Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.6 дахь хэсэг | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулах, мөрдөн ажиллах.                                                                                     |
| 3         | 2017-2018 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр ажил гүйцэтгүүлсэн. | 2017-2018 он   | 76.65                  | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                                                                     | 2016-2017 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгах, худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллах. |
| НИЙТ ДҮН: |                                                                                                                 |                | 279.15                 |                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                      |